Rio Tinto

Соёлын өвийг чухалчлахын учир

Соёлын өвийн менежментийн талаар Рио Тинто компаний хүлээдэг үүрэг амлалт хандлагын тухай ерөнхий тойм

“Соёл хийгээд соёлын өвд хүндэтгэлтэй хандах нь Рио Тинто компанийн бизнес үйл ажиллагааны салшгүй хэсэг юм. Бид хаана ч үйл ажиллагаа явуулсан тухайн нутгийн соёлын өвийг хамгаалах талаар орон нутгийн болон уугуул нутгийн хүмүүстэй хамтран ажилладаг. Учир нь, соёлын өвийг хамгаалах нь угаасаа зөв зүйтэй ажил бөгөөд бизнесийн хувьд ч чухал ач холбогдолтой гэж бид үздэг.”
– Рио Тинто төмрийн хүдэр ба Рио Тинто Австрали компанийн Гүйцэтгэх захирал Сэм Волш

Монгол улсын 2010 оны үндэсний баяр наадмын сурын харвааанд оролцож буй Аюушийн Цэвээн гуай. Монгол улсын үндэсний баяр наадам эрийн гурван наадмыг Оюу Толгой төсөл дэмжин ажилладаг. Эрийн гурван наадам нь ЮНЕСКО-гийн Дэлхийн биет бус соёлын өвийн жагсаалтад бүртгэгдсэн билээ.

Энэхүү баримт бичигт “Соёлын өв чухал болох нь: Рио Тинто компанийн орон нутгийн харилцааны ажилд соёлын өвийн менежментийг тусгах тухай” гарын авлагад орсон Рио Тинто компанийн соёлын өвийн талаар явуулдаг менежментийн арга барил, үйл ажиллагааны талаар товч танилцуулах юм. Рио Тинто компани чухам ямар учраас бизнес үйл ажиллагаандаа соёлын өвийг чухалчлан авч үздэг, соёлын өвийг хамлаалах талаар хэрхэн ажилладаг талаар ажилчид, гэрээт гүйцэтгэгч, хамтран ажиллагч нартаа ойлгуулах зорилготойгоор энэхүү гарын авлагыг гаргаж байна.

128 хуудас бүхий уг гарын авлага нь Рио Тинтогийн соёлын өвийн менежментийн арга барил ажил гүйцэтгэлийн үнэлгээг “Хэрхэн хийх”, соёлын өвийг хамгаалах тухай олон улсын гэрээ, зарчмууд, энэ чиглэлийн сүүлийн үеийн дэвшлийн тухай “Эх сурвалж” гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Гарын авлагыг Кюнсландын их сургуулийн Уул уурхайн нийгмийн хариуцлагын төвтэй хамтран дэлхийн улс орнуудын уул уурхайд тухайн орон нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлдэг Рио Тинтогийн соёлын өвийн менежментийн бодит туршлага, соёлын өвийн мэргэжилтнүүдийн зөвлөмжийг үндэслэн боловсруулсан юм.

Соёлын өвийн менежментийг хэрэгжүүлэх бизнесийн үндэслэл, шаардлага

Рио Тинто компани үйл ажиллагаандаа соёлын өвийн үнэ цэнийг хүндэтгэдэг бөгөөд энэ нь бидний үйл ажиллагаанаас үүдэлтэй орон нутагт үүсч болзошгүй сөрөг нөлөөг аль болох багасгах, нийгмийн лицензээ хадгалж, батжуулах, тогтвортой хөгжлийн зорилтоо ахиулах, хүний эрхийг дээдлэх үүрэг хариуцлагаа биелүүлэхэд тустай юм.

Соёлын өвийн зохистой менежментийг хэрэгжүүлснээр компанийн бизнес үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг бууруулж, боломжийг сайжруулдаг. Үйл ажиллагаа явуулж эхлэх үеэс орон нутгийн хүмүүстэй соёлын өвийн чиглэлээр нийцтэй харилцаа тогтоосноор итгэлцлийг бий болгож, цаашдийн харилцан ойлголцлыг бататгаж дараагийн төслүүдийг амжилттай хэрэгжүүлэх үндэс болдог. Түүнчлэн энэ нь шинэ ажлын байр, бизнес үүсэх нөхцөл болж, орон нутгийн хүмүүс өөрийн өв соёлоороо бахархах бахархлыг улам нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Соёлын өвийн асуудлыг буруу шийдсэнээр бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг. Эдийн засаг, нийгмийн сөрөг нөлөөний улмаас орон нутгийн соёл, соёлын өвд ноцтой хохирол үзүүлж ч болзошгүй юм. Энэ нь цаашлаад орон нутгийнхныг төслийн эсрэг үзэл бодолтой болгох, төсөл хэрэгжүүлэхэд хугацаа алдах, ирээдүйд үйл ажиллагаа явуулах боломжгүй болох улмаар шүүхэд дуудагдах нөхцөлийг ч бүрдүүлэх хортой. Соёлын өвд зөвшөөрөлгүйгээр халдах нь хуулийн арга хэмжээ авахуулах, төлбөр, торгууль төлөх зэргээр компанийн нэр хүнд унахад хүргэдэг.

http://www.riotinto.com/publications

Соёлын өвийн менежментийн үндсэн үзэл баримтлалууд

Рио Тинто компанийн соёлын өвийн менежмент нь дараах үндсэн үзэл баримтлалд тулгуурладаг.

Олон төрөл зүйл
Соёлын өв олон төрөл зүйл байдаг. Соёлын өв зөвхөн түүхэн холбогдолтой, урлагийн, эсвэл ямар нэг биет зүйл байх албагүй. Соёлын өв хүмүүсийн зүрх сэтгэлд их ойрхон байдаг учир хүчтэй сэтгэгдэл төрүүлдэг.

Бизнесийн үнэ цэнэ
Соёлын өвийн үр дүнтэй менежмент нь бидний бизнес үйл ажиллагаанд маш үнэтэй хувь нэмэр оруулдаг. Муу менежмент төслийн хэрэгжилтийг саатуулах, улмаар зогсоох хүртэл сөрөг нөлөөтэй.

Зорилтод нийцэх
Соёлын өвийн менежмент нь нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байна. Бүх нөхцөлд таарах нэг менежментийн загвар гэж байхгүй.

Уялдаа холбоо
Соёлын өвийн менежмент нь бизнесийн бүхий л тогтолцоо, үйл явц, практиктай уялдаа холбоотой байх шаардлагатай.

Харилцаа
Орон нутгийн үнэт зүйлсэд хүндэтгэлтэй хандвал тэд бидний ажилд тэр хэрээр дэмжлэг үзүүлэх магадлалтай.

Өөрчлөлтийг харгалзан үзэх
Цаг хугацааны эргэлтэд өв соёл ч өөрчлөгдөн хувирдаг. Тиймээс менежмент нь үүний дагуу өөрчлөгдөж байх ёстой.

Харилцан үр өгөөжтэй байх
Соёлын өвийн зохистой менежмент нь эдийн засаг, нийгэм, байгаль орчинд өргөн хүрээтэй үр дүнг авчирдаг.

Дээд Австралийн“Хопе Даунс 4” төсөл дээр Вели Волли горхи болон төмөр замын зөрлөгийн ажлын явцад орон нутгийн Няапарли омгийн ахмадуудтай зөвлөлдөж буй зураг. Зүүнээс: Петер Сэйж (Рио Тинто Төмрийн Хүдэр компанийн судалгааны менежер), Люк Лаури (Рио Тинто төмрийн хүдэр компанийн соёлын өв хариуцсан ажилтан), Ерик Паркер, Станлэй Ватсон, Гордон Юлине, Кэйт Хол, Виктор Паркер.

Зүүн Кэйп Тауны Их сургуулийн оюутнууд Палабора уурхайн талбайд археологийн малтлага хийж байгаа нь.

Соёлын өвд хандах бидний хандлага

Рио Тинто компани хаана ч үйл ажиллагаа явуулсан тухайн орон нутгийн соёл, соёлын өвийн үнэ цэнийг хүлээн зөвшөөрч хүндэтгэлтэй ханддаг. Бизнесийн бүхий л үйл ажиллагаатай соёлын өвийн менежментийг уялдуулах нь орон нутагтай урт хугацаанд харилцан хүндэтгэл, идэвхтэй хамтын ажиллагаанд суурилсан зохистой харилцаа, хамтын ажиллагааг тогтоон барих нөхцөл болдог.

Соёлын өвд тухайн нутгийн зон олны эрт, эдүгээд эрхэмлэн дээдэлж хойч үедээ өвлүүлэн үлдээх хүсэлтэй бүх л үнэт зүйлийг багтаан үздэг. Үүнд, газар нутаг, эд өлгийн зүйлс, барилга байгууламж, үйлдвэрлэлийн бүтэц, байгалийн тогтоц, археологийн дурсгалт газар, дүрслэх урлагийн бүтээл зэрэг “биет” өвөөс гадна хэл, соёл, шашин шүтлэг, уламжлалт зан үйл, дуу хөгжим, бүжиг, тэдгээрийг гүйцэтгэх арга барил зэрэг “биет бус” өв багтана.

Соёлын өв гэдэг нь зөвхөн эртний уламжлалт эд зүйлээр хязгаарлагдахгүй бөгөөд одоо үеийнхний эрхэмлэн хэрэглэдэг аливаа эд зүйлс, газар орон, тэдгээртэй харьцах зан үйл юм. Соёлын өв нь тухайн нутгийн хүмүүсийн бусдаас ялгарах шинж төрх, хүний эрхийн үндсэн хэсэг болох бөгөөд хайгуул хийх, төсөл хэрэгжүүлэх, олборлолт явуулах нь тухайн орон нутгийн ёс заншил, уул усны унаган тогтоц зэргээс нэлээд хамааралтай байдаг.

Орон нутгийн соёлын өвийг хамгаалах, хадгалах талаар тэдэнтэй хэрхэн хамтран ажиллаж, туслах нь орон нутагтай үүсгэх бидний харилцаанд маш чухал нөлөөтэй. Байгалийн нөөцийг ашиглаж ирсэн түүхээс үзэхэд соёлын өвийн талаар хангалттүй менежмент явуулснаас зөрчил маргаан үүсч улмаар орон нутгийн ард олонд ч, бизнесийн үйл ажиллагаанд ч ихээхэн хохирол учирсан жишээ цөөнгүй байдаг. Харин соёлын өвийн талаар зөв зохистой менежмент явуулах нь эдийн засгийн хөгжил, нийгмийн тогтвортой байдал, байгаль орчныг хамгаалахад ихээхэн тус нэмэр оруулдаг юм.

Тиймд Рио Тинтогийн Орон нутгийн харилцааны стандартад заасан шаардлагын дагуу Рио Тинто компанийн бүхий л үйл ажиллагаа соёлын өвийн менежментийн тогтолцоотой уялдсан байх учиртай. Соёлын өвийн менежментийн тогтолцоо нь орон нутгийнхантай дор дурдсан соёлын өвийн асуудлаар ойр дотно байж, тэдний хүсэл бодлыг тусгасан байнгын харилцаа, хамтын ажиллагааг багтаасан байх шаардлагатай. Үүнд:

- орон нутгийн хүмүүсийн үнэт зүйлсийг хүндэтгэн үзэх;
- бат бэх харилцаа тогтооход хувь нэмэр оруулах;
- орон нутгийн хүмүүс хүлээн зөвшөөрөхүйц өөрчлөлтийн хязгаарыг тогтоох;
- ирээдүйд орон нутагт эдийн засаг, нийгмийн болон байгаль орчны үр өгөөж авчрах;
- бизнесийн эрсдэл, төслийн ажил удаашрах, зардал өртөг нэмэгдэх нөхцөлийг багасгах, хэлэлцээр хийх нөхцөлийг бүрдүүлэх;
- Рио Тинто компани, түүний явуулж буй бизнесийн үйл ажиллагааны нэр хүндийг өргөх.

“Соёл, соёлын өвийг анхааран үзэх нь орон нутгийн харилцаанд чухал ач холбогдолтой хэмээн Рио Тинто компани үздэг. Соёл нь тухайн нийгмийн бусдаас ялгарах шинж, хөгжлийнх нь үндэс, соёлын өв нь үе үеийн хүмүүс хойч үедээ уламжлуулан дамжуулах өв баялаг нь билээ. Бидэнд итгэх орон нутгийн ард олны итгэл улам нэмэгдээсэй гэж бид хүсдэг. Бид орон нутгийн соёлын өвийг хүндэтгэн хамгаалж, энэ талаар хамтран ажилласнаар тэдний итгэлийг олох боломжтой.”
- Орон нутгийн харилцаа, нийгмийн асуудал хариуцсан Ерөнхийлөгч Брюус Харвей

Бид соёлын өвийн менежментийг хэрхэн хэрэгжүүлдэг вэ

Соёлын өвийн менежментийг хэрэгжүүлэх явцад урьдчилан таамаглашгүй сорилт тулгардаг. Гэсэн ч соёлын өвийн талаар орон нутгийн ард олонтой идэвхтэй харилцаа тогтоон ажиллах нь тухайн орон нутагт ашиг тустай байхаас гадна Рио Тинто компанийн бизнес үйл ажиллагааны үндсэн зарчмыг хамгаалан хөхиүлэн дэмждэг болохыг бидний туршлага харуулж байна.

Олон талт харилцаа: Бидний үндсэн зорилго бол олон талыг хамруулсан харилцаа тогтооход оршино. Энэ нь тухайн орон нутгийн нийгэм, эдийн засаг, улс төрийн зэрэг бүхийл бүлгийн төлөөллийг оролцуулсан харилцаа тогтоохыг хэлнэ.

Танин мэдэх, ойлгох: Тухайн орон нутгийн хүндлэн дээдэлдэг газар нутаг, эд өлгийн зүйл, газрын төрх байдал, эко систем, зан заншлыг танин мэдэхийн тулд бид орон нутгийн ард олны үгийг анхааралтай сонсч, соёлын өвийн мэргэжилтнүүдтэй хамтран ажилладаг. Ингэснээр орон нутагт ашиг тустайгаар бизнесийн үйл ажиллагаанаас гарч болох нөлөөллийг хэрхэн зөв зүйтэй зохицуулах талаар ойлгож авдаг. Орон нутгийн хүлээн зөвшөөрөхүйц өөрчлөлтийн хязгаарыг тодорхойлоход мөн тустай юм.

Төлөвлөх, хэрэгжүүлэх: Орон нутгийн соёлын өвийн асуудлыг тодорхойлж мэдсэнээр бизнесийн үйл ажиллагаанаас гарч болох сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, эсвэл сөрөг нөлөөг яаж багасгах, орон нутагт оногдох үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжийг тусгасан хамтран ажиллах төлөвлөгөө, хөтөлбөр, бусад үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлдэг.

Хяналт, үнэлгээ хийх, сайжруулах: Соёлын өвийн талаар орон нутгийн иргэдтэй тохиролцсон зорилтдоо хүрч буй эсэх, үйл ажиллагаагаа хэрхэн явуулж байгаагаа тогтоосон горимын дагуу хянаж үнэлдэг. Энэхүү хяналт, үнэлгээний ажилд орон нутгийн иргэд, Рио Тинто компанийн ажилтнууд, соёлын өвийн мэргэжилтэн, тухайн соёлын өвийг хадгалагчид оролцдог.

Тайлагнах, мэдээллэх: Соёлын өвийн талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагаагаа тайлагнан, мэдээлэх нь дотоод гадаад компаний ил тод байдлыг хангах, санал зөвлөгөө авах, яриа хэлэлцүүлэг өрнүүлэхэд нэн тустай. Түүнчлэн бид орон нутгийн ард иргэдэд соёлын өвөө нийтэд сурталчлан таниулах, хадгалан хамгаалахад тусалдаг. Орон нутагт дуу, бүжиг, урлаг, спорт, аман түүх, залуу үеийнхэн, эмэгтэйчүүдэд зориулсан хөтөлбөр зэрэг соёлын арга хэмжээ, орон нутгийн эрүүл мэнд, боловсролын хөтөлбөрүүдийг дэмжих замаар соёлыг нь хөхиүлэн дэмждэг.

Рио Тинто компани нь олборлолт, боловсруулалт хийгээд бусад бүх үйл ажиллагаандаа соёлын өвийн менежментийг уялдуулан хэрэгжүүлэхийг зорьдог. Энэ чиглэлээр бидний хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, арга барил, ур чадвар нь бидий өнөөгийн болон ирээдүйд хамтран ажиллахыг зорьж буй орон нутгийн иргэдтэй тогтоох харилцааны мөн чанарыг тодорхойлох юм.



Зүүн
Австралийн Аргайл алмазын гүний уурхайд нэвтрэх хэсэгт нутгийн уугуул эзэд уламжлалт газар нутагт нь уурхайн ажилчид аюулгүй нэвтрэн ороход зориулан Мантегийн тусгай зан үйл гүйцэтгэж байгаа нь. Уг зан үйл нь тухайн газар нутгийн соёлын ач холбогдлыг ойлгуулж байгаа хэрэг юм.

Дээд
Ромын үед хэрэглэж байсан уурхайн ус зайлуулах модон хүрдний хэсэг. Үүнийг 1870 онд Испани улсын Андалусия, Хуелва дахь Рио Тинто компанийн зэсийн уурхайгаас олсон бөгөөд 2010 онд Рио Тинто компани Британийн музейд хандивласан юм.

© Британийн музейн сан хөмрөгөөс

Үр дүнтэй соёлын өвийн менежментийн жишээ

Эдгээр жишээгээр орон нутгийнхантай хамтран ажиллах, хүлээн зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаар тогтоох, ажилтнууддаа соёлын өвийн талаар ойлгуулах зэрэг Рио Тинтогийн соёлын өвийн менежментийн тогтолцооны үндсэн хэсгийг танилцуулж байна. Гарын авлагаас бусад олон жишээг харж болно.

Рио Тинто Алкан, Австрали

Австралийн Кэйп Йорк дахь Вэйпа нутгийн уугуул эзэд нь газар оронтойгоо сэтгэл зүрхээрээ гүн холбоотой байдаг. Уг газар нь бокситын нөөц ихтэй орд юм. Рио Тинто Алкан компани Таниквит овгийн хүмүүстэй нягт хамтран ажиллаж Дорнод Андом уурхайн соёлын өвийн менежментийн төлөвлөгөөнд тэдний санаа зовниж буй асуудлыг бүрэн дүүрэн шийдэхээр тусгасан. Ялангуяа компани голын эрэг хавийн тусгай газрыг хамгаалах төлөвлөгөө боловсруулан, уг газрын ач холбогдлын талаар тухайн газар ирж буй хүмүүст тайлбарлан таниулж, уурхайн ажилтнуудад орон нутгийн хүмүүсийн соёлыг хэрхэн хүндэтгэх талаар сургалт явуулсан байна. Үр дүнд нь уурхай болон уугуул иргэдийн хооронд бат бэх харилцаа тогтсон.

Оюу Толгой, Монгол

Оюу Толгой нь дэлхийн хамгийн том зэс, алтны орд бөгөөд төслийн цар хүрээнээс хамааран тухайн бүс нутаг дахь соёлын өвд учрах нөлөөлөл үлэмжхэн байж болзошгүй юм. Оюу Толгой төсөл соёлын өвийн менежментийн шинэ загвар тогтоохоор зорин ажиллаж байна. Үүний дагуу үндэсний болон олон улсын мэргэжилтнүүдийн баг орон нутаг бусад сонирхогч талын төлөөлөлтэй хамтран “хүлээн зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаар” тогтоохоор ажиллаж байна. Энэ нь уул уурхай соёлын өвд хэрхэн нөлөөлөх, олон нийтийн хөтөлбөр соёлын өвийг хэрхэн хамгаалах, орон нутаг ямар хэмжээний өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч болохыг тодруулна. Орон нутгийн ард иргэд, Засгийн газар, бизнесийн байгууллага хамтран ажиллаж, соёлын өвд тулгарч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, тухайн эрсдлээс сэргийлэх арга замыг тогтоож, үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх болно.

Ричардс Бэй Минералс, Өмнөд Африк

Дэлхийн хөнгөн цагааны томоохон ордын нэг Квазулу Наталын уурхайн талбайд олборлолт явуулахаас өмнө археологи, соёлын дурсгалт газар байгаа эсэхийг судлах урт хугацааны хөтөлбөр хэрэгжүүлсэн билээ. Бид Мбонамби нутгийн хүмүүсийн хүсэлтийн дагуу Засгийн газартай хамтран Мананга соёлын өвийн төвийг байгуулсан бөгөөд уг төвд орон нутгийн соёлын өв, түүхийг хадгалан аялал жуулчлалыг хөгжүүлж байна. Энэ төвд түүхэн яриа, уламжлалт зан үйл, соёлын эд өлгийг хадгалдаг. Энэ нь тус бүс нутгийн баялаг аман түүхийг хадгалан хойч үед нь уламжлуулан хүргэхэд тустай үйл болсон юм.

Диавик алмазын уурхай, Канад

Канадын умард хэсэгт орших Диавик алмазын уурхай нутаг орны хүмүүсийн газар нутгаа ашиглах уламжлалыг хүндэтгэн байгаль орчныг хамгаалах байдлаар бизнесийн үйл ажиллагаа явуулахыг эрмэлзэн ажиллаж байна. Үүнийг уурхайн үйл ажиллагааны нөлөөнд өртөж буй уугуул иргэдийн таван омог, Засгийн газар, уурхайн төлөөллөөс бүрдсэн зөвлөх хороо хэрэгжүүлдэг. Энэ ажлын хүрээнд орон нутгийн хүмүүсийн гүйцэтгэж буй ойролцоох гол мөрөн, нуурын загасны судалгаа, бугын сүргийг хамгаалж хашаа татах зэрэг ажил багтсан байна. Ийнхүү уламжлалт мэдлэг, зан үйлийг уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан холбосноор орон нутгийн иргэдтэй элдэг харилцаа тогтоож, хуулиар олгосон болон нийгмийн лицензээ хадгалж байдаг.

Кеннекотт зэсийн уурхай, АНУ, Юта муж

Бингам Канионий уурхай нь дэлхийн хамгийн анхны, хамгийн том зэсийн ил уурхай бөгөөд АНУ-ын үндэсний түүхт газар юм. Компани хот суурин газарт уурхайн үйл ажиллагаа явуулах нийгмийн лицензээ хадгалахад тус болох, орон нутгийн иргэдтэй сайн харилцаа тогтоох, уг бүс нутагт уур уурхайн оруулж ирсэн түүхэн хувь нэмэр болон эдүгээгийн ач холбогдолыг ухуулан таниулахад чиглэсэн ажил хийжээ. Бингам Канионийн зочдын төвийг 1992 онд нээсэн бөгөөд одоогоор гурван сая зочдод ашигт малтмал, уул уурхайн түүхийн тухай мэдээлэл өгч, орон нутгийн хүмүүнлэгийн үйлсийг дэмжин тусалдаг. Зочдыг хүлээж авах энэ төв бусад соёлын өвийн адил уул уурхай нь орон нутгийн соёлын нэг хэсэг болдгийг харуулж байна.

Нэмэлт мэдээлэл:

Рио Тинтогийн соёлын өвийн менежмент болон үйл ажиллагааны бусад жишээний талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг “Соёлын өв чухал болох нь: Рио Тинто компанийн орон нутгийн харилцаанд соёлын өвийн менежментийг тусгах тухай” гарын авлагаас үзнэ үү.

Үүнийг Рио Тинтогийн менежемент, ажилтан ажилчид, гэрээт гүйцэтгэгч, соёлын өвийн мэргэжилтнүүдэд зориулсан болно. Гарын авлагыг дараах цахим хуудаснаас авч болно.
http://www.riotinto.com/publications

Нэмэлт мэдээллийг мөн дараах хаягт хандан авч болно.

Элизабет Брадшоу
Орон нутгийн харилцаа ба Соёлын өвийн ерөнхий зөвлөх
Цахим шуудан:
elizabeth.bradshaw@riotinto.com